



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: ШУТИС, Үйлдвэрлэлийн технологийн сургууль

Хөтөлбөрийн нэр: Хүнсний чанар, аюулгүй байдал

Индекс: 072103 бакалавр

Шинжээчийн баг:

Ахлагч: Ч. Нарангэрэл Витафит милк ХХК-ийн Үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал,
доктор

Гишүүд: Ц. Баярмаа Техник технологийн дээд сургуулийн захирал, профессор
Д. Найдандорж ХААИС-ийн Мал аж ахуй, биотехнологийн сургуулийн
ахлах багш, доктор

2023 он

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Үйлдвэрлэлийн технологийн сургууль Mongolian University of Science and Technology	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Хүнсний чанар, аюулгүй байдал Food quality and safety	
Индекс	D072103	
Шинжээчид	Гишүүдийн нэр, ажил, албан тушаал: 1. Ахлагч: Ч.Нарангэрэл Витафит милк ХХК-ний Үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал, ТДС-ийн профессор, Ph.D. 2. Гишүүн: Ц. Баярмаа ТТДС-ийн захирал, профессор 3. Гишүүн: Д. Найдандорж ХААИС-ийн МААБС-ийн ахлах багш, Ph.D	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн Н.Түмэнжаргал	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
	2023.04.27	Сургуулийн орчин нөхцөл, лаборатори, анги танхим, номын сантай танилцах
		Тайлантай холбоотой илрэл нотолгоотой танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга авах
		Оюутнуудтай хийх уулзалт
		Төгсөгчидтэй хийх уулзалт /цахим/
	2023.04.28	Ажил олгогчидтой хийх уулзалт /цахим/
		Багш нартай хийх уулзалт
		Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга авах
Шинжээчийн баг магадлан итгэмжлэлийн эцсийн шийдвэрийг бус, урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэх		
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

ШУТИС нь их сургуулийн бүтэц, зохион байгуулалт болон дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд 2014-2015 оны хичээлийн жилээс сургалтын хөтөлбөрүүдийг шинэчлэн, улмаар шинэчилсэн хөтөлбөрүүдийн магадлан итгэмжлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлж эхлээд байна.

Хүнсний чанар, аюулгүй байдал хөтөлбөрийн зорилго нь Хүнсний чанар, аюулгүй байдлын үндсэн мэдлэгтэй, холбогдох үйлдвэр, аж ахуйн газар, эрдэм шинжилгээний болон төрийн байгууллагад чанарын албаны ажилтан, эрдэм шинжилгээний ажилтан, хүнсний аюулгүй байдлын хяналтын мэргэжилтнээр ажиллах чадвартай боловсон хүчнийг бэлтгэхэд оршино.

Хүнсний чанар, аюулгүй байдал мэргэжлээр төгсөгч нь хүнс үйлдвэрлэлийн үндсэн суурь мэдлэгтэй, онолын мэдлэг дээрээ тулгуурлан хүнсний сүлжээний бүх үе шатанд аюулгүй байдлыг хангах, түүнд тавих хяналтыг зохион байгуулах; түүхий эд, бүтээгдэхүүний лабораторийн дүн шинжилгээнд үнэлгээ өгч, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зохион байгуулж чаддаг; холбогдох үйлдвэр, аж ахуйн газар, эрдэм шинжилгээний болон төрийн байгууллагад чанарын албаны ажилтан, эрдэм шинжилгээний ажилтан, хүнсний аюулгүй байдлын хяналтын мэргэжилтнээр ажиллах чадвартай мэргэжилтэн болж бэлтгэгдэнэ.

Хөтөлбөрөөр төгсөгч нь төгссөнөөс хойш 5 жилийн дараа бүтээлч, хариуцлагатай, мэргэжлийн ёс зүйтэй, бусадтай баг болох түүнчлэн багийг удирдлагаар хангах чадвартай бие хүн болсон байх бөгөөд үйлдвэрлэл, бизнесийн тогтвортой хөгжлийг хангахад мэдлэг ур чадвараа дайчлан ажилладаг мэргэжилтэн байна.

“Хүнсний чанар, аюулгүй байдал” мэргэжлийн хөтөлбөрийн дэвшүүлж буй зорилгын хүрээнд сургалтын хөтөлбөрийн зорилт нь дараах зүйлд чиглэгддэг. Үүнд:

1. Онолын мэдлэг, мэргэжлийн дадлагад тулгуурлан үйлдвэрлэл, үйлчилгээг зохион байгуулах, хөтлөн явуулах, технологийн урсгалын дагуу хяналт тавих,
2. Дэвшилтэт технологи хэрэглэх, нэвтрүүлэх, үйлдвэрлэлийг технологи - эрүүл ахуй, ариун цэвэр, хөдөлмөр хамгааллын шаардлагад нийцүүлэн өөрчлөн зохион байгуулах, үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадал хэвшүүлэх,
3. Хүнсний хэрэглээний уламжлал болон шинэ чиг хандлагад нийцүүлэн уламжлалт бүтээгдэхүүний жор, технологийг шинэчлэн сайжруулах, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн бий болгох,
4. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанарын судалгаа, үнэлгээ хийх, хүнсний технологи, зохистой хэрэглээний талаар ажиллагсад, хэрэглэгчдэд сургалт явуулах чадвар эзэмшүүлэх зэрэг болно.

Үйлдвэрлэлийн Технологийн Сургуулийн “Хүнсний чанар, аюулгүй байдал” хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэхээр шийдвэрлэж, ҮТС-ийн захирлын 2021 оны 05 сарын 23-ны өдрийн А/23 тоот тушаалаар ажлын хэсгийг байгуулан ажилласан байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- БСШУС-ын сайдын баталсан бакалаврын хөтөлбөрийн нийтлэг шаардлага
- ШУТИС-ийн эрхэм зорилго, алсын хараа, баримтлах бодлого, инженерийн боловсролын CDIO аргазүйн үндсэн шаардлага, жишиг, стандарт.
- Хөтөлбөрийн хорооны журам.
- Гадаадын их, дээд сургуулиудын Хүнсний аюулгүй байдал, Хүнсний аюулгүй байдал, чанарын менежмент, Хүнсний чанар, аюулгүй байдал сургалтын хөтөлбөртэй хийсэн харьцуулалт
- Дотоодын их, дээд сургуулиудын хичээлийн харьцуулалт (ХААИС, ТДС, АШУУИС)

Онцлог зүйл:

- Мэргэжлийн удиртгал хичээлийг хөтөлбөрөөр төгсөгчидтэй хамтран төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг.
- Нийт хичээлийн 29%-ийг ерөнхий суурь, 30%-ийг мэргэжлийн суурь, 35%-ийг мэргэжлийн хичээл эзэлж байна.
- Гадаадын сургуулиудтай харьцуулсны үр дүнд Чанарын удирдлагын үндэс-2кр, сонгон хичээлд, Чанарын хяналт, баталгаажилт 2кр хичээлийг мэргэжлийн суурь хичээлд, “Хүнсний сүлжээний төслийн хяналт” 3 кр хичээлийг заавал судлахаар шинээр нэмж оруулсан.
- “Оюутны туршилт, судалгааны ажил” 2 кр хичээлийг нэмж оруулахаар тусгасан нь “ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөний тэргүүлэх чиглэл “Судалгааны төгөлдөршил”-д “Монгол Улс, олон улсын хэмжээнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхүйц судалгааг хөгжүүлнэ” гэсэнтэй нийцэж байна.
- Уг хөтөлбөрөөр төгсөгчдийн бакалаврын зэргийн дипломыг гадаадын их, дээд сургуулиуд хүлээн зөвшөөрсний нотолгоо нь 2015-2019 онуудад суралцсан 13 төгсөгч Австрали, БНХАУ, Унгар, БНСУ-ын их сургуулиудын магистрантурт суралцаж төгссөн байна.

Анхаарах асуудал:

- Ажил олгогчид, төгсөгчдийн төлөөллийн зүгээс хүнсний үйлдвэрлэлийн салбарт хүнсний чанар, аюулгүй байдлын мэргэжилтний эрэлт хэрэгцээ байдаг тул мэргэжлийн хувьд хамгийн их эрэлттэй мэргэжилтэн гэдгээр анхаарч үзэх.

Дүгнэлт: Хүнсний технологийн бүх хичээлийг YTC-ийн Хүнсний инженерчлэлийн салбарын мэргэшсэн, доктор, магистр зэрэгтэй, чадварлаг багш, профессорууд заадаг. Багш нарын өөрсдийн бэлтгэж, боловсруулсан мэргэжлийн ном, сурах бичиг, гарын авлага, нэмэлт материалтай тул ургамал, амьтны гаралтай түүхий эд боловсруулах технологи болгон багцалж, багц цагийг 6 кр хүртэл нягтруулсан байна. 2022-2023 оны хичээлийн жилийн А улирлын байдлаар тус хөтөлбөрөөр нийт 67 оюутан идэвхтэй суралцаж байна. Мөн өмнөх онуудад элссэн ч төгсөөгүй үргэлжлүүлэн суралцаж байгаа 9 оюутан байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн хөтөлбөрийн сайжруулалтыг тогтмолжуулах

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- “Хүнсний чанар, аюулгүй байдал” бакалаврын хөтөлбөрийн зорилго зорилт.
- Хүнсний чанар, аюулгүй байдлын үндсэн мэдлэгтэй, холбогдох үйлдвэр, аж ахуйн газар, эрдэм шинжилгээний болон төрийн байгууллагад чанарын албаны ажилтан, эрдэм шинжилгээний ажилтан, хүнсний аюулгүй байдлын хяналтын мэргэжилтнээр ажиллах чадвартай боловсон хүчнийг бэлтгэх зорилготой.
- Төгсөгчдийн мэргэжлийн мэдлэг чадварын түвшин, үнэлгээ.

Онцлог зүйл:

- Сургуулийн удирдлага, багш нарын зүгээс төгсөгчидтэй уулзалт хийх мэргэжлийн талаар сэтгэл ханамжийн судалгааг явуулдаг зэргээр эргэх холбоо сайн хийгддэг.
- Төгсөгчдөөс сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг сайжруулах, шинэ хөтөлбөрийн зорилго, төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлох зорилгоор судалгаа, санал асуулга авч, дүгнэлт хийдэг.
- Сургууль, багш, оюутан, төгсөгчдийн эргэх холбоо их сайн байна.

Дүгнэлт: Хөтөлбөрийн зорилгод хүрэх зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд оюутнуудыг дадлагажуулж, чадваржуулах зорилгоор сургалт, судалгааны лабораторийг үе шаттайгаар өөрчлөн шинэчилж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Тус хөтөлбөрөөр сургалт явуулж буй зарим хичээлийн агуулгад сайжруулалт хийх талаар анхаарах. Үүнд: онолын мэдлэг дутмаг, орчин үеийн багаж төхөөрөмжтэй ажиллах талаар сул гэж ажил олгогчид санал хэлж байсан.

- Сургалтын орчин, материаллаг баазыг (тоног төхөөрөмж) сайжруулах, судалгааны орчин үеийн арга зүй, сурах бичиг (зарим мэргэшүүлэх), багш нарын хөгжлийг дэмжихэд анхаарах хэрэгтэй.

Зөвлөмж:

- Мэргэшүүлэх зарим хичээлийн ном сурах бичгийн хангамжийг нэмэгдүүлэх

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн сургалтын ажил эрхлэх №960009 дугаар тусгай зөвшөөрөл
- Сургалтын төлөвлөгөөний хичээлүүд ба хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт хоорондын хамаарлыг харуулсан сургалтын төлөвлөгөөний матриц
- Сургалтын хөтөлбөрийн хичээл бүрийн агуулга, зорилго өөр бусад хичээлтэй хэрхэн холбогдох, тухайн хичээлээр олж авсан мэдлэг нь ямар хичээлийн үндэс суурь болох, өөрөөр хэлбэл нэг хичээлээр үзсэн мэдлэг, чадвар дараагийн ямар хичээлийн үндэс болох залгамж холбоо.

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийн баримт бичиг, үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг баримт бичгийн бүрдэлт бүрэн бэлтгэгдсэн байна.
- АПУ ХК, Талх чихэр ХК, Милл Хаус ХК, Алтан тариа ХК, Витафит ХК, Сүү ХК, Мах импекс ХК, Жүр үр ХК, MSC Кока Кола үйлдвэр, Атар Өргөө ХХК, Чингис шар айраг ХХК, Сtimo ХХК, Хатан сүйх ХК, ТЭСО ХХК зэрэг хүнсний үйлдвэрүүд, УМХГ, НМХГ, зэрэг үйлдвэрүүдэд хийлгэдэг.
- Хүнсний аюулгүй байдлын удирдлагын ISO 9001, ISO 22000 стандартууд, HACCP, GHP, GMP тогтолцооны тухай асуудлуудыг Чанарын хяналт, баталгаажуулалт, Хүнсний аюулгүй байдал I, Хүнсний аюулгүй байдал II хичээлүүдийн агуулгад оруулсан байна.
- “Хүнсний чанар, аюулгүй байдал” хөтөлбөрийг “Хүнс үйлдвэрлэлийн технологи, эрүүл ахуй” мэргэжлийн хөтөлбөрт тулгуурлан 2014 онд шинэчлэн боловсруулж, 2016, 2018 онд дахин сайжруулсан.
- Сургалтын хөтөлбөрт чанар, эрүүл ахуйн хичээлийн эзлэх хувийг нэмэгдүүлсэн.

Анхаарах асуудал: Төгсөгчдөөс мэргэжилтэй холбоотой хууль эрх зүй, ёс зүйн талын мэдлэг олгох чиглэлээр сэдэв оруулах хүсэлт байгааг уламжилсан.

Дүгнэлт: Сургалтын хөтөлбөрийн бодлого, бүтэц, агуулга нь зорилго, зорилт, Төв болон салбар сургуулийн хөгжлийн чиглэлтэй нийцсэн, нийгэм, зах зээлийн өөрчлөлттэй уялдан

тасралтгүй шинэчлэгдэх хандлагатай, тухайн мэргэжлээр төгсөгч нь ажил олгогчдын шаардлагад үндсэндээ тохирч байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Зарим хичээлийн агуулга, үр дүнд дүн шинжилгээ хийх

1-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын төлөвлөгөөний бүтэц /2007, 2018 оны сургалтын төлөвлөгөөнд хийсэн харьцуулалт/
- Төгсөгсдөөс сургалтын төлөвлөгөөнд үнэлгээг авсан судалгаа
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлсон
- Хөтөлбөрийн төлөвлөгөөний хичээлүүд, түүний суралцахуйн үр дүнгийн матриц

Онцлог зүйл:

- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017.06.29-ний өдрийн А52 тоот тушаалаар “072103 Хүнсний чанар, аюулгүй байдал” мэргэжлийн хөтөлбөр батлагдсан бөгөөд энэхүү хөтөлбөрийг нийт 120 багц цаг байхаар боловсруулсан байна.
- Сургалтын хөтөлбөрийн агуулга, багц цагийн харьцааг гадаад дотоодын сургуулиудтай харьцуулсан байна.
- Хөтөлбөрийн агуулгыг БШУС-ын А/174 тушаал “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ын хүрээнд 120 сургалтын багц цагтай, Үүнд ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлийн харьцаа /28.3: 30.0: 41.7/ байгаа нь дээрх тушаалын 2.2.1 заалтын шаардлагыг хангаж байна.

Дүгнэлт:

- 2007 онд батлагдан мөрдөгдөж байсан “Хүнсний үйлдвэрлэлийн технологи, эрүүл ахуй” сургалтын төлөвлөгөө нь 138 кр цагийн ачаалалтай байсныг 2018 онд батлагдсан “Хүнсний чанар, аюулгүй байдал” сургалтын төлөвлөгөөнд 120 кр цагийн ачаалалтайгаар шинэчлэн боловсруулсан нь БШУС-ын А/174 тушаалаар батлагдсан Бакалаврын хөтөлбөрт тавигдах шаардлагыг хангаж байна.

- Төгсөгчдийн санал асуулгыг жил бүр авч үр дүнг нэгтгэн дүгнэж сургалтын төлөвлөгөөний агуулга шинэчлэлийг хийж сургалтын агуулгад тусгаж оруулсан байна.
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлж, хичээл хоорондын хамаарлыг матриц байдлаар гаргасан нь давуу талтай байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Мэргэшүүлэх хичээлийн заавал судлах “Ургамлын гаралтай хүнс үйлдвэрлэлийн технологи” болон “Амьтны гаралтай хүнс үйлдвэрлэлийн технологи” хичээлийн лабораторийн ажилд технологийн хэсгийг оруулах
- Зарим курсын оюутны тоо харьцангуй цөөн байгаа нь оюутан бүр өөрийн сонирхсон “сонгон” хичээлийг зарим улиралд хязгаарладаг тул элсэлт дээр анхаарах

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн 2021 он хүртэлх мастер төлөвлөгөө
- 2020 онд батлагдсан ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө
- Сургалтын арга зүй, суралцахуйн зорилтот үр дүнгийн уялдаа холбооны загвар
- ШУТИС-ийн Ректорын 2014 оны 04 сарын 14-ний өдрийн А/64 тушаал “ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллааг зохицуулах журам”

Онцлог зүйл:

- CDIO арга зүйн сургалтын идэвхитэй аргыг ашигладаг.
- Сургалтад цахим, танхим хосолсон арга зүйг хэрэгжүүлдэг.

Дүгнэлт:

- CDIO арга зүйн сургалтын идэвхтэй аргуудыг нэвтрүүлэх талаар жил бүр оюутны амралтын хугацаанд сургалт зохион байгуулсны дүнд багш нар 2016-2017 оны хаврын улирлаас сургалтын идэвхтэй аргуудыг нэвтрүүлэхээр анхааран ажиллаж байна.
- Багш нар хичээлдээ томъёолох-хуваалцах-бий болгох-дахин боловсруулах, MUD карт, галерей үзэх, ерөнхий ойлголтын асуултууд ашиглах гэх мэт идэвхитэй сургалтын аргыг хослуулан хэрэглэдэг нь суралцахуйн үр дүнг оюутанд хүргэх дэвшилтэд арга зүй болж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хөтөлбөрт ашиглаж байгаа сургалтын арга зүйд дүн шинжилгээ хийж, оюутны сэтгэх, бүтээх чадварыг хөгжүүлэхэд илүү анхаарах

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн Ректорын 2014 оны 04 сарын 14-ний өдрийн А/64 тушаал “ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”
- Сургалтын арга зүйд хичээл бүрийн дүнгийн шинжилгээ нь UNIMIS системд 70:30 онооны харьцаагаар дүнгийн шинжилгээг хийгдэж байна.
- Сурлагын амжилтаараа тэргүүлдэг суралцагчдыг (голч 3.6 ба дээш) урамшуулдаг буюу захирлын нэрэмжит хуудсанд бичигддэг. 2 ба түүнээс дээш бичигдсэн бол сургуулийн шилдэг оюутанаар шалгаруулж, ШУТИС-ийн шилдэг овутны сангаас урамшуулдаг байна.
- ШУТИС-ийн Ректорын 2014 оны 04-р сарын 14-ны өдрийн А/64, 2015 оны 09-р сарын 01-ний өдрийн А/188 тоот тушаалаар явцын болон төгсөлтийн шалгалтын журам
- Удирдлага мэдээллийн “UNIMIS” ‘программыг ашигладаг.
- Хичээл бүрээр шалгалтын сорилын сангийн бүтэц, агуулгатай.

Онцлог зүйл:

- Удирдлага мэдээллийн UNIMIS программаар үнэлгээ болон бусад мэдээллийг хүргэдэг, ашиглалт тогтмолжсон.
- Суралцагчийг үнэлэхдээ “ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг баримтлан хийдэг.
- Сургалтын албанд хичээл тус бүрээр бүрдүүлсэн суралцагчийн мэдлэг, ур чадварыг үнэлэх сантай.
- Улирлын эцэст сургалтын албанаас хичээл тус бүрийн 70:30 онооны харьцааг гаргаж дүн шинжилгээ хийдэг байсан бол ШУТИС-ийн UNIMIS системийн шинэчлэлийг явуулсны үр дүнд хичээл тус бүрийн дүнгийн шинжилгээ хичээл орсон багшид шууд вэбээр харагддаг давуу тал юм.

Дүгнэлт:

- “Хүнсний чанар, аюулгүй байдал” сургалтын хөтөлбөр нь эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журмын хүрээнд суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлдэг арга зүйтэй, суралцагчдыг удирдлага мэдээлэлээр хангах UNIMIS программ нь хангалттай ажиллаж байна.
- Оюутнууд сургалтын орчинд туршилт судалгааны ажил хийх боломжоор хангагдсан байгаа нь оюутан бодит орчинд суралцаж, мэдлэг, ур чадвараа сайжруулах боломжийг бүрдүүлжээ.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Мэргэжлийн хөтөлбөрийн хувьд хичээлийн үнэлгээ, арга зүйг сайжруулах чиглэлээр мэргэжлийн тэнхимийн багш нараас гадна ажил олгогчдын төлөөлөлийг оруулах, бусад тэнхимээс тухайн хөтөлбөрт ордог хичээл, түүний үнэлгээ, арга зүйд анхаарч хөтөлбөр төвтэй ажиллах.

2-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

- “Хүнсний чанар, аюулгүй байдал” хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагаа нь суралцагчийн эзэмших мэдлэг ур чадвар, хандлагыг тогтоох онол, практикийн зохих харьцаатай, сургалтын агуулгыг дээд боловсролын бакалаврын хөтөлбөрт тавигдах

шаардлагын дагуу боловсруулсан. Холбогдох дээд байгууллагын тушаал, шийдвэрийн дагуу шинэчлэн боловсруулсан зэрэг агуулгын шинэчлэл хийгдсэн байна.

- Сургалтын арга зүй нь оюутан төвтэй, тэдний оролцоог дэмжсэн, суралцах орчинг бүрдүүлсэн, уламжлалт сургалтын аргаас гадна CDIO-ийн идэвхтэй сургалтын арга зүйг ашиглаж байгаа нь төгсөгчдийн үр чадвараас харагдаж байна.
- Суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг түвшин тогтоох үнэлгээгээр үнэлж, цаашдын ахиц дэвшлийг улирлын, дадлагын үнэлгээ, дипломын төсөл /ажил/, улсын шалгалтын үнэлгээ зэргээр үнэлэх зэргээр сургалтын үйл ажиллагааг явуулж байна.

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Дээд боловсролын сургалтын байгууллагын норм норматив, эрүүл ахуйн стандартын шаардлага, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан 2473.1 м2 ашигтай талбай бүхий байранд сургалтын үйл ажиллагааг эрхлэн явуулж байна.
- Хөтөлбөрт хамаарах лекц, семинарын 8 танхим, сургалт-судалгааны 7 лаборатори, багш нарын өрөө 5, захиргааны ажилчдын 3 өрөө, компьютерийн лаборатори, виртуаль лаборатори, сургалтын алба ШУТИС-ийн хичээлийн I байранд, харин сургалт-судалгааны 2 лаборатори, лекц, семинарын 1 танхим, ҮТС-ийн номын сан (Монгол Улсын хоёр дахь ерөнхийлөгч Н.Багабандийн нэрэмжит) ШУТИС-ийн хичээлийн T байранд байрладаг.
- Лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хичээлийн хэрэглэгдэхүүний хангаж хүрэлцээг орчинд нь танилцсан байдал
- Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн сан, БНХАУ-ын ӨМӨЗО-ны “Хөдөө аж ахуйн их сургууль” хамтран “Монгол-Хятадын хамтарсан Молекул биологийн хэрэглээний лаборатори”-ийг 2016 онд БШУЯ-ны харьяанд байгуулсан бөгөөд 2020 онд ШУТИС, Үйлдвэрлэлийн Технологийн сургуульд шилжүүлсэн болно.

Онцлог зүйл:

- Монгол, Францын хамтарсан төслөөс Биотехнологи, шим тэжээлийн салбарын Хими, биохимийн лабораторид 162.8 сая төгрөгийн багаж тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад хөрөнгө үнэ төлбөргүй хүлээлгэн өгч лабораторийн баазыг бэхжүүлсэн.
- Сургалт-судалгааны 9 лабораторийн үйл ажиллагаатай шинжээчийн баг нэг бүрчлэн танилцсан ба лабораториуд нь тус хөтөлбөрөөр суралцагчдад шинжлэн судлах зохих тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан нь хөтөлбөр хэрэгжих сургалтын орчинг бүрдүүлсэн байна.
- Дээрх лабораториудад багш, оюутнуудын туршилт судалгаа, эрдэм шинжилгээний ажил, төгсөлтийн ажлын туршилтууд явагдаж, хүнсний найрлага, шинж чанар, аюулгүй байдлын шинжилгээ хийх бүрэн чадамжтай байгаа нь давуу талтай.

Дүгнэлт:

- Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг.
- Сургуулийн дотоод орчны өнгө үзэмж, ая тухтай бөгөөд аюулгүй байдалд анхаарч жил бүр засвар, үйлчилгээ хийж, тавилга хэрэгслээр тохижуулж ирсэн. Тайлант хугацаанд (2018-2021 он) нийт 219 орчим сая төгрөгийг урсгал завсарт зарцуулсан.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Химийн бодис, урвалжийн тэмдэг тэмдэглэгээ болон ашиглалтыг журмын дагуу хөтлөн явуулах
- Итгэмжлэгдсэн лабораторийн үйл ажиллагааг идэвхжүүлэх
- Химийн бодис, урвалж хадгалах, зориулалтын агуулахыг ашиглалтанд оруулж, зохих журмыг мөрдөн ажиллах.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн Захирлын 2020 оны 04-р сарын 30-ны А/67 тоот тушаалаар цахим сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам баталж, мөрдөж ажилладаг. 2021 оны 11 сараас танхимын сургалтанд бүрэн шилжин ажиллаж байна.
- 2020 оны 2 сараас MICROSOFT TEAMS-365 программыг албан ёсны зөвшөөрлийн лицензтэй хэрэглэх болсон нь цахим сургалтыг тасралтгүй явуулах боломжоор хангагдсан. Мөн TEAMS-ийн FORMS-ийг ашиглан шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна.
- ХЧАБ хөтөлбөрийн хувьд лабораторийн хичээлийн кредит тутамд оюутан бүрд 10-15 мянган төгрөг зарцуулж байна.
- Багш нарын компьютер, техник хэрэгсэлийн хангамж хүрэлцээ
- Анги кабинетуудын хичээлийн хэрэглэгдэхүүнээр хангагдсан байдал
- Багш нарын хичээлийн хэрэглэгдэхүүний бүрдэлт

Онцлог зүйл:

- ШУТИС цахим сургалтанд шилжсэнтэй холбоотой цахим сургалтын цэсэнд (LMS Багш (must.edu.mn)) багш өөрийн тухайн улиралд зааж байгаа хичээлийн материалыг PDF хэлбэрээр байршуулна. Энэ материалыг тухайн хичээлийг сонгон үзэж байгаа оюутнууд хичээл орохоос өмнө уншиж судлан бэлтгэдэг. Мөн багш энэхүү цэсийг ашиглан хичээлийн даалгавар өгч, өгсөн даалгаврын биелэлтийг оюутан тус бүрээр шалгаж дүгнэх, мэдээлэл хүргэх боломж бүрдсэн.
- 2021 онд сургалтын тоног төхөөрөмж, эд хогшлын шинэчлэлд 62,810 мян. төг /ҮТС-ийн хэмжээнд/ зарцуулсан байна.
- Багш нар сургалтын хөтөлбөртэй холбоотой хичээлийн материалуудаа цахимжуулсан
- Багш нарын бэлтгэсэн мэргэжлийн ном, гарын авлага, товхимол номтой танилцав.

Дүгнэлт:

- Тус хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад зориулагдсан сургалтын хэрэглэгдэхүүн болон программ хангамжаар бүрэн хангагдсан, тасралтгүй сайжруулалт хийснээр үйл ажиллагаанд олон давуу тал бий болж байгаа талаар багш, оюутны уулзалтын үеэр дахин батлагдаж байсан.

Үнэлгээ: Бүрэн хангасан

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн номын сангууд нь Стандартчлал, хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2007 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага-MNS 5742:200”
- ШУТИС-ийн Захирлын 2018 оны 11-р сарын 30-ны өдрийн А/232 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан “ШУТИС-ийн Шинжлэх ухаан, технологийн номын сангийн үйл ажиллагааг зохицуулах журам”
- ШУТТНСангийн веб сайт <http://www.must-library.edu.mn> эсвэл электрон каталогийн сайт <http://opac.must.edu.mn>
- ШУТТНС нь нийт 1575 м2 талбай, 696 суудал бүхий уншлагын танхим, 273 м2 талбай, 160 суудалтай бие даалтын танхимаар үйлчилж байна.
- Хөтөлбөрт хэрэглэгдэх ном сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний нөөцийн судалгаа, номын сангийн үйл ажиллагаатай танилцсан байдал

Онцлог зүйл:

- Номын сан нь электрон каталогитой ШУТТНСангийн веб сайт <http://www.must-library.edu.mn> эсвэл электрон каталогийн сайт <http://opac.must.edu.mn> хаягаар хаанаас ч хайлт хийж ашиглах боломжтой давуу тал байна.
- “Цахим номын сан” (<http://www.must-library.edu.mn/m/29>) вэб сайтыг тогтмол баяжуулан профессор багш, ажилтан, оюутнуудын хүртээл болгож байна. Цахим номын сан нь 1600 гаруй Е-ном, эрдэм шинжилгээ, судалгааны материал, дүрэм журмаас бүрдэх фондтой бөгөөд зохиогчийн эрх шийдэгдсэн бүтээлүүдийг цаасан хэлбэрээс хөрвүүлэн ISSUU, Flipping Book Publisher 2.2 программыг ашиглан тодорхой хамгаалалттайгаар бүрэн эхээр нь оруулж фондыг баяжуулдаг.

Дүгнэлт:

- Номын сангийн үйл ажиллагаа бүрэн цахимжсан, олон жил ажилласан туршлагатай хүн ажилладаг ба ном сурах бичгийн баяжилтын судалгааг хийж үзэхэд дээд боловсролыг суурь хичээлийн 368 нэрийн сурах бичиг, мэргэжлийн суурь ба мэргэшүүлэх хичээлийн 48 нэрийн 718 ном, сурах бичиг, гарын авлагаар баяжсан тухайн хөтөлбөртэй хамаарал бүхий ном байгаа зэрэг сайн талууд байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

3-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

- Тус хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, хөтөлбөрөөр суралцагчдыг амжилттай суралцах сургалтын байр орчин, хэрэглэгдэхүүнийг бүрдүүлэх талаар байнгын сайжруулалт хийж ирсэн байна.
- Сургалтын түшиц газруудад сургалт, үйлдвэрлэлийг хослуулан явуулж багш, суралцагчдыг бодит орчинд дадлагажин суралцах боломжийг бий болгож байгаа нь хөтөлбөрөөр төгсөгчид ажлын байранд амжилттай ажиллах боломжийг бий болгож байна.
- Судалгаа, шинжилгээний лабораториудыг 2016 оноос шинэчлэн байгуулж, гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрт хамрагдан дэвшилтэт технологи бүхий орчин үеийн багаж, тоног төхөөрөмжөөр тоноглож сайжруулсан нь хөтөлбөрөөр суралцагсад болон эрдэмтэн багш нарын судалгаа, шинжилгээ хийх, сургууль дээрээ дадлагажих боломжийг бүрдүүлсэн байна.

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэл
- Мөрдөгдөж буй дүрэм, журмууд ШУТИС-ийн цахим хуудсанд тавигддаг.
- Хөтөлбөрт ирсэн санал гомдол, шийдвэрлэлтийн тайлан
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны тайлан, төлөвлөгөө.
- Тайлан төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдалд хийсэн дүн шинжилгээ

Онцлог зүйл:

- Удирдлагын мэдээллийн нэгдсэн систем бүрэн нэвтэрч хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хороогоор хэлэлцсэн асуудлыг Их сургуулийн нэгдсэн хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлэн баталгаажуулж мөрдөж байна. Microsoft Them программыг ашиглан хичээлийн агуулга материалыг байршуулан цахим сургалтыг явуулж байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой буюу сургалтын өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах эрхзүйн 16 баримт бичгийг мөрдөж ажилладаг.
- ШУТИС-ийн хэмжээнд 2006 оноос орчин үеийн мэдээлэл, харилцааны технологид суурилсан удирдлагын мэдээллийн UNIMIS системийг нэвтрүүлсэн. Сургалтын албаны програмыг лавлах, харах, оюутны бүртгэл, тайлан гаргах, тохируулга хийх, хичээл, дүнгийн бүртгэл, статистикийн мэдээ гаргах үйл ажиллагаанд ашигладаг.

- ҮТС-ийн зүгээс сургалтын орчны нөхцөл, хичээлийн хуваарийн давхцал, мэргэжлийн багшийн асуудлаар оюутнуудаас ирсэн аливаа санал гомдлыг шийдвэрлэж ирсэн.
- “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн шалгуурыг 2020 онд гаргажээ. Хичээлийн жил бүрийн эхэнд ШУТИС-ийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулан багш, ажилтан бүр гүйцэтгэх ажлын төлөвлөгөө гаргаж, улмаар салбарын эрхлэгч нэгтгэн салбарын төлөвлөгөөг боловсруулж, бүрэлдэхүүн сургуулийн захирлаар батлуулж ажилладаг.
- Оюутан өөрийн цахим хуудсаа ашиглан хувийн мэдээлэл, сургалтын төлөвлөгөө, санал болгох төлөвлөгөө, хичээлийн хуваарь, төлбөрийн мэдээлэл, үлдэгдэл төлбөр, хичээл тус бүрийн явцын сорилын дүн, багшийн үнэлгээ, улирлын шалгалтын дүн, дүнгийн ерөнхий мэдээлэл, цуглуулсан кредит, үнэлгээний голч дүн, номын сангаас авсан номын жагсаалт зэргийг харна. Мөн хичээл сонгол хийх, сургалтын төлбөрөө онлайнар төлөх, E-баримтаа e-майл хаягаар авах, санал асуулгад оролцох боломжтой.
- Багш өөрийн цахим хуудсаар дамжуулан зааж буй хичээлийн явцын сорил, ирц идэвх, бие даалтын үнэлгээг оруулахад оюутан бүрт шууд харагдана. Харин улирлын шалгалтын үнэлгээг сургалтын албанаас оруулснаар тухайн хичээлийн эцсийн үнэлгээ оюутанд цахим хуудсаар дамжин шууд мэдээлэгдэнэ.

Дүгнэлт: ШУТИС-иас баталсан дүрэм, журмаар зохицуулагдан сургалтын чанарыг сайжруулахад чиглэгдсэн, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч салбарын профессор, багш нарыг удирдлагаар ханган зөвлөж, чиглүүлдэг байна. Дотоод гадаадын олон хөтөлбөрт хөтөлбөр хэрэгжүүлэгч салбарын багш нар урт, богино хугацаагаар хамрагддаг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайланд ахиц дэвшлийн талаар гарсан үр дүнд харьцуулсан шинжилгээ хийх, дүгнэлт гаргаж мөрдөх

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн жагсаалт
- Гадаад багш, зочин профессор, мэргэжилтнийг урьж ажиллуулах журам, ШУТИС-ийн профессор, багш, ажилтан гадаадад томилолтоор ажиллах, суралцах, мэргэжил дээшлүүлэх (А/68) журмыг мөрддөг.
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны баримт материал
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулсан талаарх тоон мэдээлэл

Онцлог зүйл:

- Компани, аж ахуйн нэгж, ажил олгогч байгууллагуудтай хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ байгуулж удирдамжийн дагуу оюутны сургалт болон үйлдвэрлэлийн дадлагыг хийлгэдэг.
- Тайлант хугацаанд гадаадтай хамтран гүйцэтгэсэн 10, хэрэгжүүлж буй 6 төсөл байна. Үүнээс 5 улсын 5 их сургуулийн эрдэмтдийн хамтран хэрэгжүүлж буй REMIX-төсөл, Биоматериал ба эдийн инженерчлэл нэртэй 2019 оны 9 сард ШУТИС дээр зохион байгуулагдсан зуны сургалтыг онцлож байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хамт олон нь гадаадын 10 орчим, дотоодын 30-аад их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, үйлдвэр, аж ахуйн газруудтай хамтын ажиллагааны гэрээтэй ажилладаг.
- БНХАУ-ын Хөх хотын ХААИС-ийн судлаачидтай хамтран “Бэлчээрийн монгол адууны хүнсний үнэт чанар, түүнд нөлөөлөх генийн судалгаа” /2018-2020 он/ ШУТСангийн төсөл, “Нэг бүс нэг замын орнуудын адуун сүргийн бүтэн геномын секвенсийг тодорхойлох” /2020-2022 он/ төслүүдийг хэрэгжүүлэв. Япон улсын их, дээд сургуулиудтай хамтран “Инженер технологийн дээд боловсрол” (MJEED) төслийг хэрэгжүүлэн тус бүр 3 багш, ажилтан докторын зэрэг хамгаалж, мэргэжил дээшлүүлжээ.

Дүгнэлт: Хөтөлбөр хэрэгжүүлэгч салбар нь гадаад, дотоодын ижил төстэй сургалт, хүнсний үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд мэргэжил дээшлүүлэх, давтан сургах, дадлагажуулах, сургах, сургалт зохион байгуулах, зөвлөн туслах зэрэг чиглэлээр хамтран ажилладаг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- ҮТС-ийн орлогын бүтэц, бүрдүүлэлт, зардлын задаргааны хүснэгт
- ШУТИС-ийн оюутнуудад тэтгэлэг, кредитийн урамшуулал олгох журам (Ректорын 2022 оны А/136)
- Нэг суралцагчид ногдох өртөг зардлын тооцоо
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт
- Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайлан

Онцлог зүйл:

- ҮТС-ийн 2021 оны орлого нь сургалтын төлбөр (78,14%), түр сургалт, оюутны байрны орлого, түрээс, эрдэм шинжилгээ, судалгааны орлого, бусад орлого, төсвийн санхүүжилт зэргээс бүрдэж байна. Харин нийт зардлын 67 хүртэл хувийг сургалттай холбоотой шууд зардал, 30 орчим хувийг шууд бус зардал, 1 хүртэл хувийг оюутны үйлчилгээний зардал эзэлж байна.

- Сургуулийн хэмжээнд жилийн төсвийг Удирдах зөвлөлийн хурлаар батлуулж төсвийн гүйцэтгэлийн тайланг тогтмол гарган баримтжуулдаг. Сургалтын төлбөрөөс гадуур эрдэмтэн багш нарын хувьд гадаадын хамтарсан болон үндэсний хэмжээний төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн сургалт, судалгааны орчинд бодит хөрөнгө оруулалтыг хийж ажилладаг.
- Тайлант хугацаанд Хүнсний чанар, аюулгүй байдал хөтөлбөрийн 33 суралцагч шилдэг оюутнаар шалгарч 29 кредитийн урамшуулалд хамрагдсан байна. Сүүлийн 5 жилд гадаадын байгууллагын тэтгэлэгт 4 оюутан хамрагдаж, 12 сая төгрөгийн тэтгэлэг авчээ.

Дүгнэлт: Хөтөлбөр хэрэгжүүлэгч салбар сургууль нь сургалт, эрдэм шинжилгээ, олон нийтийн үйл ажиллагааг хэвийн явуулахад чиглэсэн санхүүгийн тодорхой эх үүсвэртэй. Профессор, багш нарыг хөгжүүлэхэд жил бүр 20-25 сая төгрөгийг төсөвлөн, үйл ажиллагаа явуулдаг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Сургалтын төлбөр нь хичээл практикийн зардлыг бүрэн нөхөж чадахгүй байгаад анхаарах
- Нэг оюутанд ногдох зардлыг нарийвчлан судалж бодитоор тооцох
- Эрдэм шинжилгээний төслийн төсвөөр сургалт судалгааны лабораторийн материаллаг баазыг сайжруулж байгаа нь төдийлэн хангалттай бус байгааг анхаарч багш, оюутнуудын идэвхи санаачилгыг өрнүүлэх

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- “ШУТИС-ийн стратеги-2030” баримт бичиг
- ШУТИС-ийн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн жагсаалт
- ҮТС-ийн цахим хуудас, видео контент, линк

Онцлог зүйл:

- Тухайн мэргэжлийн зах зээлийн хэрэгцээ, ажлын байрны эрэлтийн судалгааг хүнсний үйлдвэр, эрдэм шинжилгээний байгууллагуудаас авч, үр дүнг нь тооцож ажилладаг.
- Мэргэжлийн сурталчилгааг тогтмол хийдэг. Тайлант хугацаанд ЕБС-ийн сурагчдыг сургууль дээрээ хүлээн авч мэргэжил сурталчлах өдөрлөгийг хэд хэдэн удаа зохион байгуулсан байна. Үүнд: ЕБ-ын 111-р сургуулийн 9, 10, 11, 12-р ангийн нийт 26 сурагчид 2018.11.23-нд, Баянхонгор аймгийн 10 сурагч, 2 багшийг 2022.10 сард хүлээн авч ҮТС-ийн 10 лаборатори болон номын сангийн үйл ажиллагаатай танилцуулсан.
- 2 багш 2020.10 сард Малчин ТВ-ийн “Өргөн сэдэв” нэвтрүүлэгт, 2 багш 2021.10, 11 сард ШУТИС-ийн FM радиод ярилцлага өгч улс орон даяар мэргэжлийн танилцуулгыг хийжээ.

Дүгнэлт: Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэйгөөс гадна хөтөлбөрийг нийтэд танилцуулах ажилд олон талт мэдээллийн эх сурвалжуудыг ашигладаг. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан мэргэжил

сурталчлах болон салбарын профессор, багш нарын эрдэм шинжилгээний ажлыг түгээн дэлгэрүүлэх зэрэг олон чиглэлээр үйл ажиллагаа тогтмол явуулдаг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- ҮТС-ийн танилцуулга
- ҮТС-ийн цахим хуудас
- “Хүнс судлал” багш, оюутны эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл
- “Биотехнологи-бидний амьдралд” оюутны эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл
- ҮТС-ийн элсэгчдэд зориулсан тараах материал

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийн талаарх мэдээллийг түгээх сонин, сэтгүүл, ЭШХ-ын эмхэтгэл, танилцуулга, гарын авлага, вэб хуудастай. Тухайлбал, БШТС-аас жил бүр зохион байгуулагддаг “Биотехнологи-бидний амьдралд”, “Хүнс судлал” оюутны эрдэм шинжилгээний хурал, олон арга хэмжээний зар, мэдээ мэдээллийг тогтмол байршуулдаг.
- Тухайн хөтөлбөрөөр суралцагсадыг оюутны эрдэм шинжилгээний хуралд, олимпиадад оролцуулж гаргасан амжилтын талаар мэдээлэл гаргадаг.

Дүгнэлт: Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Төгсөгчдийн зүгээс санал болгож буй хүсэлт буюу мэргэшүүлэх төлбөртэй сургалтыг зохион байгуулж хөтөлбөрт зарцуулагдах төсвийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх
- Тус хөтөлбөрөөр элсэн суралцагсдын тоо буурч байгаагаас хөтөлбөрт зарцуулагдах төсөвт хүндрэл гарах эрсдэл байгааг анхаарч элсэлтийн менежментийг сайжруулах
- Төгсөгчдийн холбооноос явуулж буй мэргэжлийн сурталчилгаа, бусад мэдээлэл гаргаж буй цахим мэдээллийн линкийг суралцагч оюутнуудтай холбож мэргэжлийн мэдээллээр хангах ажлыг өргөжүүлэх

4-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн захирлын 2022.09.22-ны А/252 тушаал /Элсэгч суралцагчдыг оюутнаар батлах тухай /
- ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь технологийн сургуулийн захирлын 2022.01.25-ны А/03 тушаал /Оюутны шилжилт, хөдөлгөөний тухай/
- ШУТИС-ийн захирлын 2021.09.21-ний А/164 тушаал /Оюутанаар батлах тухай/
- ШУТИС-ийн захирлын 2021.09.21-ний А/165 тушаал /Элсэгч суралцагчдыг оюутанаар батлах тухай/
